

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-145-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт</p> <p align="center"><i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/24 хуудас/2017 оны NZ amend.14</i></p>	<p align="center">ИНД-145 - АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 19 хуудас (үндсэн дүрэм- 14 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.6</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/GENERAL</p>	
<p>145.1. Зорилго Энэ Дүрэм нь Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>145.1. Зорилго/Purpose (a) Энэ дүрмээр Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага (цаашид Техник үйлчилгээний байгууллага гэх)-ыг гэрчилгээжүүлэх болон түүний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>145.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>145.3. Тодорхойлолт/Definitions</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>145.5. Гэрчилгээний шаардлага Хэрэв ИНД-43, 121, 125, эсхүл 135-ын дагуу агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээг энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллагаар, эсхүл түүний эрхийн хүрээнд хийлгэх шаардлагатай бол, (энэ дүрмийн дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд зааснаас бусад тохиолдолд) аливаа этгээд нь агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийхгүй, эсхүл тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхгүй байх үүрэгтэй.</p>	<p>145.5. Гэрчилгээнд тавигдах шаардлага / Requirements for certification (a) Энэ дүрмийн 145.11-ийн дагуу Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээгээр олгогдсон эрх болон зөвшөөрөгдсөн нөхцлөөс бусад эрхийг эдлэхийг аливаа этгээдэд хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан, тавигдах шаардлага amend.1-ээр дэлгэрэнгүй болсон</p>
<p>145.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах (a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах мэдээллийг шаардсан САА 24145/01 маягтыг бөглөх үүрэгтэй: (1) хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад үйлчилгээ үзүүлэх хаяг; (2) хүсэлт гаргагчтай холбоотой Даргын шаардаж болох, маягтад заасан нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл. (b) Хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА 24145/01 маягтыг зохих төлбөрийн баримтын хамт Даргад ирүүлнэ.</p>	<p>145.7. Өргөдөл гаргах/Application for certificate (a) <u>Өргөдөл гаргагч нь</u> <u>ИНЕГ-145/01</u> маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх) -ын даргад ирүүлнэ. (б) ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг шаардаж болно.</p>	<p>-Amend.11-ээр өөрчлөгдсөн</p>
<p>145.9. Гэрчилгээ олгох Хэрэв <u>Дарга</u> дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь ТҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй: (1) <u>хүсэлт гаргагч нь</u> В Бүлгийн шаардлагыг хангасан;</p>	<p>145.9. Гэрчилгээ олгох/Issue of certificate (a) <u>ИНЕГ-ын</u> дарга дараах тохиолдолд Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээг олгоно: 1/ <u>өргөдөл гаргагч</u> энэ дүрмийн Бүлэг Б-д заасан шаардлагуудыг хангасан; 2/ <u>өргөдөл гаргагчийн</u> энэ дүрмийн 145.51-ийн (a)-д заасан</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p>

<p>(2) 145.51(а)-ийн дагуу шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;</p> <p>(3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын <u>ашиг сонирхолд</u> харшлахгүй байх.</p>	<p>удирдах албан тушаалтнуудтай байна;</p> <p>3/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.</p>	
<p>145.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх</p> <p>(а) ТҮБ-ын гэрчилгээнд тухайн гэрчилгээгээр олгогдсон, байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан дараах 1, эсхүл хэд хэдэн техник үйлчилгээний зэрэглэлийг заасан байна:</p> <p>(1) А1 - МСТOW нь 13 610 кг-аас дээш жинтэй агаарын хөлгийн техник үйлчилгээ;</p> <p>(2) А2 - МСТOW нь 5700 - 13 610 кг хүртэл жинтэй агаарын хөлгийн техник үйлчилгээ;</p> <p>(3) А3 - МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс бага жинтэй шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна 10, эсхүл түүнээс дээш гэрчилгээжсэн максимум зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээ;</p> <p>(4) А4 - МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна 9, эсхүл түүнээс цөөн гэрчилгээжсэн максимум зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээ;</p> <p>(5) С1 - агаарын хөлгийн хөдөлгүүр болон сэнсний техник үйлчилгээ;</p> <p>(6) С2 - бүрдэл хэсгийн техник үйлчилгээ;</p> <p>(7) С3 - агаарын хөлгийн цахилгааны төхөөрөмжийн техник үйлчилгээ;</p> <p>(8) С4 - агаарын хөлгийн хэрэглэлийн төхөөрөмжийн техник үйлчилгээ;</p> <p>(9) С5 - агаарын хөлгийн радио төхөөрөмжийн техник үйлчилгээ;</p> <p>(10) Е1 - агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн сургалт хийх;</p> <p>(11) F1 - агаарын хөлгийн бүртгэгч улстай байгуулсан техникийн зохицуулалтын дагуу, гадаадын агаарын хөлөг болон гадаадын агаарын хөлгийн бүрдэл хэсгийн техник үйлчилгээ;</p> <p>(12) P1 - агаарын хөлөг болон бүрдэл хэсэгт хийх, дээр дурдсан зэрэглэлд өөр байдлаар заагдаагүй техник</p>	<p>145.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх / Privileges of certificate holder</p> <p>(а) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээг техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт нь тусгагдсан, дор заасан нэг буюу түүнээс дээш техник үйлчилгээний ангилалаар олгоно:</p> <p>1/ А1-<u>хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин</u> нь 5700 кг-аас дээш агаарын хөлөгт хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>2/ А2-хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин нь 5700 кг хүртэл агаарын хөлөгт хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>3/ С1-агаарын хөлгийн хөдөлгүүр болон сэнсэнд хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>4/ С2-агаарын хөлгийн хөдөлгүүр болон сэнснээс бусад бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>5/ С3-агаарын хөлгийн цахилгааны тоног төхөөрөмжид хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>6/ С4-агаарын хөлгийн хэрэглэлийн тоног төхөөрөмжид хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>7/ С5-агаарын хөлгийн радио холбооны тоног төхөөрөмжид хийгдэх техник үйлчилгээний ажил;</p> <p>8/ Е1-агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтанд сургалт зохион байгуулах;</p> <p>9/ F1-агаарын хөлгийн бүртгэгч улстай байгуулсан техникийн гэрээ хэлэлцээрийн дагуу гадаадын агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт хийх техник үйлчилгээний ажил;</p> <p>10/ P1-дээр дурьдсан ангилалуудад тусгагдаагүй агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх техник үйлчилгээний ажил.</p>	<p>-МСТOW - Хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин гэж орчуулсныг хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин болгосон. А1-5700 кг-аас дээш байсан нь 13 610 кг-аас дээш болсон А2-5700 кг хүртэл байсан нь 5700 кг-аас дээш 13 610 кг-аас доош болсон.</p> <p>-А3, А4 -ангилал нэмэгдсэн</p> <p>-Amend.12-оор өөрчлөгдсөн</p>

<p>үйлчилгээ; (13) S1 - агаарын хөлгийн эд анги шилжүүлэх мэдэгдэл олгох; (14) S2 - материал шилжүүлэх мэдэгдэл олгох; (15) S3- шатах тослох материал шилжүүлэх мэдэгдэл олгох.</p> <p>(b) 145.60-ыг харгалзан, ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн гэрчилгээжсэн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх зөвшөөрлийг аливаа этгээдэд олгож болно.</p> <p>(c) 145.60-ыг харгалзан, ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн гэрчилгээжсэн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх зөвшөөрлийг аливаа этгээдэд олгож болно.</p>	<p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД-66-ын дагуу үнэмлэх эзэмшсэн, техник үйлчилгээний ажилтанд ИНД-145.60–д заасан нөхцлөөр агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт техник үйлчилгээг гүйцэтгэх эрхийг олгож болно.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД-66-ын дагуу үнэмлэх эзэмшсэн техник үйлчилгээний ажилтанд ИНД-145.60–д заасан нөхцлөөр агаарын хөлөг эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах эрхийг олгож болно.</p>	<p>-ИНД-66 –ийн дагуу үнэмлэх эзэмшсэн хүнд өгнө гэж хүндрүүлсэн утгын алдаатай.</p>
<p>145.13. Гэрчилгээний хугацаа</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.</p> <p>(b) ТҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, хүчинтэй хэвээр байна.</p> <p>(c) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол, тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.</p> <p>(d) ТҮБ-ын гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.</p>	<p>145.13. Гэрчилгээний хугацаа / Duration of certificate</p> <p>(a) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаагаар олгож шинэчилнэ.</p> <p>(б) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дуусах, эсхүл гэрчилгээг ИНЕГ-ын дарга түр түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.</p> <p>(в) ИНЕГ-ын дарга гэрчилгээг хүчингүй болгосон эсхүл гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дууссан нөхцөлд эзэмшигч гэрчилгээг нэн даруй ИНЕГ-т ирүүлнэ.</p> <p>(г) ИНЕГ-ын дарга гэрчилгээг түр түдгэлзүүлсэн нөхцөлд гэрчилгээ эзэмшигч цаашид авах арга хэмжээнд зориулан гэрчилгээг ИНЕГ-т нэн даруй ирүүлнэ.</p>	<p>-appropriate endorsement – цаашид авах арга хэмжээнд зориулан гэснийг зохих тэмдэглэл хийлгэхээр гэж утгын алдааг зассан.</p>
<p>145.15. <u>Техник үйлчилгээг</u> зогсоох мэдэгдэл</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь техник үйлчилгээг санал болгохоо зогсоосон тухайн өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдэгдлийг, ТҮБ-ын гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийн хамт гаргана.</p>	<p>145.15. <u>Үйл ажиллагаагаа</u> зогсоох <u>тухай</u> мэдэгдэл / Notification of ceasing maintenance</p> <p>(a) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаагаа зогсоох болсон тохиолдолд энэ тухайгаа зогсоох өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад бичгээр мэдэгдэнэ.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдэгдэлд техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээг хүчингүй болгуулах тухай хүсэлтийг багтаасан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>145.17. Гэрчилгээ сунгах</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтийг CAA 24145/01 маягтын дагуу гаргана.</p>	<p>145.17. Гэрчилгээний <u>хүчинтэй хугацааг сунгуулах</u> / Renewal of certificate</p> <p>(a) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-145/01 маягтын дагуу өргөдөл гаргана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) Тухайн хүсэлтийг гэрчилгээнд заасан сунгах хугацаанд, хэрэв сунгах хугацааг заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.</p>	<p>(б) Өргөдөл гаргагч нь гэрчилгээнд заасан хүчин төгөлдөр огноо дуусахаас 30 буюу түүнээс доошгүй хоногийн өмнө хүсэлтийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	
<p>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА / CERTIFICATION REQUIREMENTS</p>	
<p>145.51. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</u></p> <p>(1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу хийж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;</p> <p>(2) тухайн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд. Удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх ёстой:</p> <p>(i) техник үйлчилгээний ажиллагааг удирдах, хянах;</p> <p>(ii) ажилтанд эрх олгох;</p> <p>(iii) 145.65-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;</p> <p>(3) Ерөнхий зааварт заасан техник үйлчилгээний үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.</p> <p>(aa) Энэ зүйлийн (a)(2)(iii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар туршлагаа харуулсан байх үүрэгтэй.</p> <p>(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа техник үйлчилгээний ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл</p>	<p>145.51. Ажилтан <u>албан тушаалтанд</u> тавигдах шаардлага/Personnel requirements</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:</p> <p>1/ өргөдөл гаргагч байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа бүр нь энэ дүрэмд заасан стандарт шаардлагуудын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;</p> <p>2/ Байгууллага нь энэ дүрмийн шаардлагуудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буйг бататгах үүрэг хүлээсэн гүйцэтгэх албан тушаалтнуудыг томилон ажиллуулна. Томилогдсон албан тушаалтнууд нь удирдах албан тушаалтны өмнө дараах үйл ажиллагааны чиглэлээр шууд хариуцлага хүлээнэ:</p> <p>2.1. Техник үйлчилгээний ажлыг удирдан зохион байгуулах, хянах асуудлыг хариуцсан;</p> <p>2.2. Техник үйлчилгээний ажилтанд эрх олгох болон сургалт дадлага хариуцсан;</p> <p>2.3. Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан;</p> <p>2.4. Аюулгүй ажиллагаа хариуцсан; (энэ заалтыг 2011 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө)</p> <p>4/ байгууллагын ерөнхий зааварт заасан техник үйлчилгээний ажлуудыг төлөвлөх, гүйцэтгэх, үзлэг хийх, хянах болон гэрчилгээжүүлэхэд хүрэлцэхүйц тооны ажилтантай байна.</p> <p>3/ ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, өргөдөл гаргагчийн бүтэц зохион байгуулалтаас хамааран энэ зүйлийн (a)-ын 2/-т заасан чанарын дотоод баталгаажуулалт болон аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэгтгэж болно;</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь:</p> <p>1/ байгууллагын зүгээс хийгдэх техник үйлчилгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, үзлэг хийх болон</p>	<p>-Орчуулга, найруулга зассан,</p> <p>-SMS-ийн нэмэлт шаардлага тавигдсан</p>

<p>(3)төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд анги болон материал хадгалах дараах байгууламжтай байна:</p> <p>(i) ажиллагаатай эд зүйлийн аюулгүйн хамгаалалтыг хангасан;</p> <p>(ii) ажиллагаатай, ажиллагаагүй эд зүйлийг ангилан тусгаарласан;</p> <p>(iii) хадгалагдаж байгаа эд зүйл гэмтэх, элэгдэхээс сэргийлсэн хяналттай.</p> <p>(с)Хүсэлт гаргагч түүний бүрдүүлсэн орчин нөхцөл нь тухайн гүйцэтгэх ажилд, ялангуяа хамааралтай НТЧ-ын өгөгдөлд заасан тусгай шаардлагад нийцсэн болохыг бататгана.</p>	<p>2.4. засвар үйлчилгээний тусгай хэсгүүд нь агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсэгт төлөвлөсөн техник үйлчилгээг гүйцэтгэхэд хангалтай хэмжээний багтаамжтай байх;</p> <p>2.5. хүрээлэн буй орчны температурын хэм нь ажилтнууд ажил үүргээ ая тухтай гүйцэтгэх боломжтой нөхцөлд байх;</p> <p>2.6. агааржуулалтын системээр тоногдсон байх;</p> <p>2.7. гэрэлтүүлэг нь аливаа үзлэг болон техник үйлчилгээг үр дүнтэй гүйцэтгэх зохих шаардлагыг хангасан байх;</p> <p>3/ эд анги, тоног төхөөрөмж, багаж, сэлбэг, материал, хадгалах агуулах нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>3.1. техник үйлчилгээ хийгдсэн эд анги, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал нь найдвартай хамгаалагдсан;</p> <p>3.2. техник үйлчилгээ хийгдээгүй, эсхүл гэмтэл дутагдалтай эд ангийг үйлчилгээ хийгдсэн эд анги, тоног төхөөрөмжөөс тусгаарласан байх;</p> <p>3.3. хадгалагдаж буй тоног төхөөрөмж, эд анги гэмтэх, чанараа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх үүднээс хяналттай байх.</p> <p>(в) Техник үйлчилгээний барилга байгууламж, засвар үйлчилгээний тусгай хэсгүүд болон албан өрөө, тасалгааны хүрээлэн буй орчин нь ажил үүргээ гүйцэтгэхэд тохирсон байх бөгөөд холбогдох тусгай шаардлагуудыг хангасан байна. Хэрэв тодорхой нөхцөлд ажиллах орчныг өөрөөр заагаагүй бол ажлын байрны хүрээлэн буй орчин нь ажилтны эрүүл мэндэд аюултай болон хортой нөлөөлөлгүй байна.</p> <p>(г) Өргөдөл гаргагчийн гүйцэтгэж байгаа ажлын орчин нь аливаа нислэгт тэнцэх чадварын өгөгдөхүүнд тусгагдсан тусгай шаардлагуудыг хангасан байна.</p>	<p>өөрчлөгдсөн</p>
<p>145.55. Төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материал</p> <p>ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:</p> <p>(1)тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх техник үйлчилгээний үйл ажиллагаанд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материалыг ашиглах боломжтой байлгана;</p> <p>(2)төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материалын хяналтыг багтаасан, нарийвчлалтай багаж болон төхөөрөмжийн тохируулгыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц давтамж болон стандартаар хийх журмыг тогтооно.</p>	<p>145.55. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон <u>сэлбэг материал</u> / Equipment, tools, and material</p> <p>(а) Өргөдөл гаргагч нь зөвшөөрөгдсөн техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэх үүднээс дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл болон сэлбэг материалын боломжтой нөөцтэй байх;</p> <p>2/ ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн стандарт болон үзлэгийн давтамжийг агуулсан, нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмжид тохиргоо хийх аргачлал бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сэлбэг материалыг хянах хяналтын журмыг тогтоосон байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>145.57. Нөөц</p>	<p>145.57. Нөөц/Reserved</p>	
<p>145.59. Техник үйлчилгээний хяналтын журам</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан техник үйлчилгээний үйл ажиллагаа бүрд шаардлагатай техник үйлчилгээний процедурын заавар, байгууламжийн заавар, инженерингийн зураг, тодорхойлолт, техникийн стандарт болон практик ажиллагааны заавар, бусад баримт бичгийн хувийг хадгалах үүрэгтэй.</p> <p>(b) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1) тухайн байгууллагад хүргэгдэх хүртэл бүрэн гүйцэд үзлэг шалгалт хийгдэх боломжгүй эд анги болон иж бүрдлийн хүлээн зөвшөөрөхүйц чанартайг бататгах аргыг багтаасан, техник үйлчилгээний салбар байгууллагын худалдан авсан, эсхүл техник үйлчилгээ хийсэн бэлдэц материал, эд анги, болон иж бүрдлийн үзлэг шалгалт хийх;</p> <p>(2) тухайн шийдвэрийн болон хүлээн авахаас татгалзсан материал, эд анги болон иж бүрдлийн устгалын бүртгэлийг багтаасан маягийн загвар, эсхүл тодорхойлолттой нийцээгүй материал, эд анги болон иж бүрдлийг зохицуулах;</p> <p>(3) дараах нөхцөлийг бататгах аргыг багтаасан, хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан техник үйлчилгээний ажиллагаа гүйцэтгэх:</p> <p>(i) хүлээн зөвшөөрөхүйц техник үйлчилгээний аргачлал болон практикийг хэрэглэх;</p> <p>(ii) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан техник үйлчилгээний гэрээний үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>(iii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт зааснаас бусад байрлалд хийгдэх техник үйлчилгээг хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт тусгайлан тодорхойлсон хуваарьт техник үйлчилгээгээр, эсхүл зөвхөн тухайн агаарын хөлгийн ажиллагаагүй байдлаас үүссэн техник үйлчилгээгээр хязгаарлах;</p> <p>(4) тухайн байгууллагын нэрийн өмнөөс туслан гэрээлэгчийн гүйцэтгэх техник үйлчилгээний үйл ажиллагаа тус бүрд дараах шаардлагыг бататгах:</p> <p>(i) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт тодорхойлдог байх;</p> <p>(ii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан</p>	<p>Техник үйлчилгээний хяналтын журмууд / Maintenance control procedures</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> байгууллагын ерөнхий зааварт заасан техник үйлчилгээний үйл ажиллагааг явуулахад шаардагдах техник үйлчилгээний заавар, ажлын байрны заавар, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн заавар, техникийн өгөгдлийн тодорхойлолт, <u>инженерингийн зураглал</u>, стандарт болон практик ажиллагааны заавар бусад холбогдох баримт бичигтэй байна.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмуудыг тогтоосон байна:</p> <p>1/ байгууллагад нийлүүлэхээс өмнө бүрэн гүйцэд үзлэг хийх боломжгүй сэлбэг, материал, эд анги, тоног төхөөрөмж нь зохих чанарын шаардлагыг хангаж буй эсэхийг бататгах аргачлалыг агуулсан, гэрээт техник үйлчилгээний байгууллагаар засвар, үйлчилгээ хийлгэсэн, эсхүл захиалсан болон худалдан авсан сэлбэг материал, эд анги, тоног төхөөрөмжид үзлэг хийх;</p> <p>2/ маягийн загвар, эсхүл техникийн өгөгдлийн тодорхойлолтод нийцээгүй эд анги, тоног төхөөрөмж, сэлбэг материалын талаар гаргасан шийдвэрийн бүртгэл, тэмдэглэлийг хийх болон тэдгээрийг актлах,</p> <p>3/ байгууллагын ерөнхий зааварт дэлгэрэнгүй тусгагдсан техник үйлчилгээний ажлуудын гүйцэтгэл нь дараах зүйлүүдийг бататгах аргачлалуудыг агуулсан байна:</p> <p>3.1. хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал болон практик ажиллагааг ашиглах;</p> <p>3.2. агаарын тээвэрлэгчдийн өмнө гэрээгээр хүлээсэн техник үйлчилгээний үүргийг биелүүлэх;</p> <p>3.3. байгууллагын ерөнхий зааварт заасан байршлаас өөр газарт техник үйлчилгээг гүйцэтгэх бол зөвхөн зааварт онцгойлон тодорхойлсон хуваарьт техник үйлчилгээг, эсхүл агаарын хөлөгт гэнэтийн дутагдал гарсан тохиолдолд хийх техник үйлчилгээг.</p> <p>4/ Өргөдөл гаргагчийн нэрийн өмнөөс гэрээт байгууллагын гүйцэтгэх техник үйлчилгээний ажил бүрийг өргөдөл гаргагч нь дор заасны дагуу бататгасан байна:</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-Орчуулга найруулга зассан</p>

тогтолцоо, журам болон тодорхойлолтыг хангадаг байх;

(5) материал, эд анги болон иж бүрдлийг таньж тогтоох, үйлчилгээ хийх, хадгалах болон баглах;

(6) 145.60-ын дагуу, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны журам болон ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрх эзэмшдэг ажилтнуудын жагсаалт хөтлөх;

(7) 145.60-ын дагуу CAA Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ гаргах эрх бүхий ажилтны журам болон CAA Form One шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ гаргах эрх бүхий ажилтнуудын жагсаалт хөтлөх;

(8) дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийг хянах:

(i) тухайн баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;

(ii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан техник үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ, ажилтан хэрэгтэй үедээ ашиглахад боломжтой байх зорилгоор, холбогдох хүчинтэй баримт бичгийг шаардлагатай байрлал бүрд бэлэн байлгах;

(iii) хүчингүй болсон баримт бичгийг олгох цэгээс, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс нэн даруй хураадаг байх;

(iv) тухайн баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;

(v) хугацаа дууссан баримт бичиг ашиглагдаагүй болохыг бататгах зорилгоор, баримт бичгийн зүйл бүрийн хүчинтэй хувилбар нь танигддаг байх;

(9) Даргын хүсэлтээр, техник үйлчилгээний мэдээлэл, инженерингийн зураг, техникийн стандарт, практик аргачлал болон үзлэг шалгалт хийсэн бүртгэлийг хүргүүлэх.

4.1. байгууллагын ерөнхий зааварт гэрээт байгууллагын талаар дэлгэрэнгүй тодорхойлсон байх;

4.2. гэрээт байгууллага нь өргөдөл гаргагчийн байгууллагын ерөнхий зааварт заасан үйл ажиллагааны тодорхойлолт, холбогдох заавар, журам болон тогтолцоог дагаж мөрдөх талаар.

5/ Эд анги, тоног төхөөрөмж, сэлбэг материалыг савлах, хадгалах, зөөх, илгээх, хүлээн авах, таних, хаяглах;

6/ энэ дүрмийн 145.60-ын дагуу эрх олгогдсон, агаарын хөлөг түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах, баталгаажуулах ажилтныг болон тус эрхийг эзэмшиж буй ажилтнуудын нэрсийн жагсаалтыг бататгах;

7/ энэ дүрмийн 145.60-ын дагуу эрх олгогдсон, “ИНЕГ Маягт Нэг-Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ”-г олгох ажилтан болон тус эрхийг эзэмшиж буй ажилтнуудын нэрсийн жагсаалтыг бататгах;

8/ энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийн хяналтыг дараах зүйлээр бататгах журам:

8.1 баримт бичиг бүрийг ашиглалтанд гаргахын өмнө эрх бүхий этгээд хянаж, баталгаажуулах;

8.2 хүчин төгөлдөр баримт бичгээр ажлын байр бүрт байгаа ажиллагсдыг хангах, тэдгээр нь байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан техник үйлчилгээний үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийг ашиглах боломжтой байх;

8.3 хүчингүй болсон баримт бичгийг ашиглалтаас хасах;

8.4 баримт бичигт аливаа өөрчлөлт, шинэчлэлт орсон тохиолдолд эрх бүхий этгээдээр хянаж, баталгаажуулсан байх;

8.5 хүчингүй болсон баримт бичгийг ашиглахаас сэргийлж, хүчин төгөлдөр баримт бичгийн хувь тус бүрийг тодорхойлж бататгах.

9/ үзлэг шалгалтын тайлан, инженерингийн зураглал, техникийн стандарт болон практик ажиллагааны заавар бусад шаардлагатай техник үйлчилгээний талаарх мэдээллийг ИНЕГ-ын даргад хүргүүлэх.

145.60. Эрх олгох журам

145.60. Эрх олгохтой холбогдсон журам / Authorisation procedures

(а) Энэ зүйлийн (b), (c), (d), (e), (f) болон (g)-г харгалзан, ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд дараах төрлийн техник үйлчилгээний үйл ажиллагааг гүйцэтгэх этгээдэд эрх олгох журмыг тогтоох үүрэгтэй:

(1) тухайн эрхэд заасан агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх болон хянах;

(2) тухайн эрхэд заасан агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийсний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх;

(3) агаарын хөлөг болон бүрдэл хэсэгт хийсэн том хэмжээний модификаци болон том хэмжээний засвар нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлэх.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй этгээд нь техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхгүй байх үүрэгтэй:

(1) ИНД-66-гийн дагуу олгосон зохих зэрэглэлтэй, хүчинтэй AMEL-тэй байх; эсхүл

(2) ИНД-66-гийн дагуу олгосон тохирох категорин хүчинтэй AMEL-тэй байх болон техник үйлчилгээний инженерийн зэрэглэл олгоход тавих, ИНД-66-гийн С Бүлэгт шаардсантай дүйцэх стандартыг хангасан байх; эсхүл

(3) хамааралгүй

(4) ИНД-66-гийн дагуу олгосон, зохих баталгаажуулсан тэмдэглэлтэй хүчинтэй MAC-тай байх; эсхүл

(5) Монгол Улсын гадна хийгдэх техник үйлчилгээний хувьд:

(i) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрхийн хүрээнд олгосон, Даргын хүлээн зөвшөөрөхүйц эрх авахаар төлөвлөж байгаа агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсгийн хүчинтэй техник үйлчилгээний инженерийн бичиг баримттай байх, эсхүл

(ii) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсаас техник үйлчилгээ гүйцэтгэхээр гэрчилгээжсэн байгууллагаас олгосон, Даргын хүлээн зөвшөөрөхүйц эрх авахаар төлөвлөж байгаа агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсгийн дүйцэх эрхтэй байх; эсхүл

(а) Өргөдөл гаргагч нь техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээгээр олгогдсон зөвшөөрлийн хүрээнд техник үйлчилгээний ажилчдад дараах төрлийн техник үйлчилгээг гүйцэтгэх эрх олгох журмыг тогтоосон байна:

1/ агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэх, хянах;

2/ техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэсний дараа агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах, баталгаажуулах;

3/ агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт хийгдсэн үндсэн засвар болон үндсэн өөрчлөлт нь зөвшөөрөгдсөн техникийн өгөгдлийн үзүүлэлтэд тохирч буй эсэхийг баталгаажуулах.

(б) энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд, дараах этгээдэд агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах эрх олгохгүй гэдгийг бататгах журамтай байна;

1/ ИНД-66-гийн дагуу олгосон, зохих зэрэглэлтэй техник үйлчилгээний ажилтны хүчин төгөлдөр үнэмлэхгүй; эсхүл,

2/ ИНД-66-ийн Бүлэг В-д шаардсан техник үйлчилгээний ажилтны зэрэглэл авах шаардлагатай адилтгах хэмжээний стандартыг хангасан болон ИНД-66-ийн дагуу зохих ангиллаар олгосон, техник үйлчилгээний ажилтны хүчин төгөлдөр үнэмлэхгүй; эсхүл,

3/ ИНД-66-ийн дагуу олгосон, мэргэжлийн үнэмлэхэд техник үйлчилгээг баталгаажуулах тэмдэглэгээ хийгдээгүй;

4/ Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хийх техник үйлчилгээний хувьд:

4.1 зөвшөөрөл нь тухайн маягийн агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт зориулагдсан, ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц, Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч гишүүн улсын эрх бүхий байгууллагаас олгосон техник үйлчилгээний ажилтны зохих баримт бичиггүй, эсхүл;

4.2 зөвшөөрөл нь тухайн маягийн агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт зориулагдсан, ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц, Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч гишүүн улсын эрх бүхий гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллагаас олгосон адилтгах хэмжээний зөвшөөрөлгүй;

-Орчуулга, найруулга зассан.

-Current aircraft maintenance engineer – техник үйлчилгээний ажилтан гэснийг техник үйлчилгээний инженер гэж орчуулсан.

(6) тухайн журамд заасан, хязгаарлагдмал техник үйлчилгээний үйл ажиллагааны дараа агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх хязгаарлагдмал эрхийн хувьд, Хууль болон ИНД-66-гийн дагуу олгосон хүчинтэй АМЕЛ-тэй, тухайн эрхийн хязгаарлалтад тохирох Даргын хүлээн зөвшөөрөхүйц сургалтад хамрагдсан болон туршлагатай байх; эсхүл

(7) ИНД-43-ын Хавсралт А.1-д заасан техник үйлчилгээний хувьд, 43.51(b)-гийн шаардлагыг хангасан ба тухайн эрх авахаар төлөвлөж байгаа маягийн агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх болон ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийн тулд зохих ёсоор сургалтад хамрагдсан байх.

(с) Хэрэв тухайн этгээд нь дараах шаардлагыг хангасан бол, техник үйлчилгээний дараа бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно:

(1) эрх авахаар төлөвлөж байгаа бүрдэл хэсэгтэй холбоотой сургалтын курсийг амжилттай дүүргэсэн, эсхүл эрх авахаар төлөвлөж байгаа бүрдэл хэсэгтэй холбоотой, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалтыг амжилттай өгсөн байх;

(2) хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, эсхүл авионикийн төхөөрөмжийг үйлдвэрлэх, засвар үйлчилгээ хийх, эсхүл өөрчлөлт хийхэд ихэвчлэн ашигладаг журам, дадлага, материал, багаж хэрэгсэл, суурь машин болон төхөөрөмжтэй холбоотой 36 сарын нисэхийн туршлагатай байх;

(3) эрх авахыг хүссэн бүрдэл хэсэгтэй шууд холбоотой, 6 сар хяналтан дор ажилласан туршлагатай байх.

(с) Энэ зүйлийн (с)(1)-д заасан сургалтын курсийг:

(1) байгууллагын ажилтнуудад сургалт хийх Е1 ангилалтай Хууль болон ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч зохион байгуулсан байх; эсхүл

(2) хэрэв сургалтын байгууллагын гэрчилгээ нь тухайн сургалтын курсийг зохион байгуулах эрх олгосон бол, Хууль болон ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллага зохион байгуулсан байх;

5/ журамд тусгагдсан хязгаарлагдмал техник үйлчилгээний дагуу агаарын хөлгийг техник үйлчилгээнээс гаргах хязгаарлагдмал эрхийн хувьд, ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц зохих дадлага туршлагагүй бөгөөд эрх олгох сургалтанд хамрагдаагүй, ИНД-66-ийн дагуу хүчин төгөлдөр техник үйлчилгээний ажилтны

үнэмлэхгүй;

6/ ИНД-43-ийн Хавсралт А.1-д заасан техник үйлчилгээний хувьд, ИНД-43-ын 4-ийн (б)-ийн шаардлагыг хангаагүй, тухайн маягийн агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх болон техник үйлчилгээнээс гаргах сургалтанд хамрагдаж, зохих зөвшөөрөл аваагүй.

(в) Дараах шаардлагыг хангасан этгээдэд агаарын хөлгийн эд анги, бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах эрхийг олгож болно:

1/ агаарын хөлгийн тодорхой эд анги болон бүрэлдэхүүн хэсэгт зөвшөөрөл олгох сургалтанд амжилттай хамрагдаж эрх авсан, эсхүл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн шалгалтыг амжилттай өгч эрх авсан бол;

2/ агаарын хөлгийн их бие, хүчний төхөөрөмж, авионикийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, өөрчлөлт, зохион бүтээлтэнд ашиглагддаг материал, багаж хэрэгсэл, суурь машин, журам заавар дээр 36 сараас доошгүй хугацаагаар ажилласан, нисэхийн мэргэжлийн дадлага туршлагатай бол;

3/ тухайн эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн засвар үйлчилгээний ажлыг 6 сараас доошгүй хугацаанд удирдан гүйцэтгэсэн дадлага туршлагатай бол;

4/ үл эвдэх сорилын аргаар үзлэг хийсний дараа эд ангийг техник үйлчилгээнээс гаргах эрх авсан бол;

5/ гагнуур хийсэн эд ангийг техник үйлчилгээнээс гаргах эрх авсан бол.

(г) Энэ зүйлийн (в)-ийн 1/-д заасан сургалтыг дараах байгууллагууд зохион байгуулах эрхтэй:

1/ Энэ дүрмийн Е1 ангилал бүхий техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;

2/ тухайн сургалтыг зохион байгуулах зөвшөөрөлтэй ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллага;

-Орчуулга,
найруулга зассан.

<p>эсхүл</p> <p>(3)холбогдох бүрдэл хэсгийн үйлдвэрлэгч зохион байгуулсан байх; эсхүл</p> <p>(4)Даргын хүлээн зөвшөөрөхүйц, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын нисэхийн эрх бүхий байгууллага зөвшөөрсөн байх ёстой.</p> <p>(e) Аливаа этгээдэд дараах эрхийг олгохгүй:</p> <p>(1)тухайн этгээд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрх:</p> <p>(i) 145.59 (b)-д шаардсан техник үйлчилгээний хяналтын заавар, журмын талаарх мэдлэгээ холбогдох удирдах ажилтнаар шалгуулсан байх;</p> <p>(ii) тухайн эзэмших эрхтэй холбоотой техникийн ур чадвараа холбогдох удирдах ажилтнаар шалгуулсан байх;</p> <p>(iii) хэрэв тухайн эрхэд, агаарын тээвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөрөөр EDTO нислэгийн зөвшөөрөлтэй байхыг тогтоосон нисэх онгоц багтсан бол, ИНД-121.407-гийн шаардлагад тохирох сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх; эсхүл</p> <p>(2)тухайн этгээд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг болон бүрдэл хэсэгт хийсэн том хэмжээний модификаци болон том хэмжээний засвар нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлэх эрх:</p> <p>(i) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрх эзэмшдэг байх;</p> <p>(ii) модификаци болон засварын тохиролд хамаарах сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх;</p> <p>(iii) модификаци болон засварын тохиролд хамааралтай, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалтыг амжилттай өгсөн байх.</p> <p>(f) Энэ зүйлийн (a)-д шаардсан журмын дагуу олгосон эрх эзэмшиж байгаа этгээд нь дараахаас бусад тохиолдолд, тухайн эрхийг хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) Хууль болон ИНД-66-гийн дагуу олгосон AMEL эзэмшиж байгаагаас үл хамааран, ИНД-66.57 болон 66.207-д заасан холбогдох туршлага хадгалах шаардлагыг хангасан байх;</p>	<p>3/ эд анги болон бүрэлдэхүүн хэсгийг үйлдвэрлэгч;</p> <p>4/ Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсын нисэхийн эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн болон ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад байгууллага.</p> <p>(д) зохих удирдах албан тушаалтанд дараах шалгалтуудыг өгөөгүй аливаа этгээд нь агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах эрхгүй гэдгийг бататгах журамтай байна:</p> <p>1/ энэ дүрмийн 145.59-ийн (б)-д заасан техник үйлчилгээний хяналтын заавар, журмын талаарх мэдлэг;</p> <p>2/ тухайн эрхийг эзэмших мэргэшлийн талаарх ур чадвар.</p> <p>(e) дор заагдсан этгээд нь агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт хийгдсэн үндсэн өөрчлөлт болон үндсэн засварыг зөвшөөрөгдсөн техникийн өгөгдөлд нийцэж буйг баталгаажуулах эрхгүй гэдгийг бататгах журамтай байна:</p> <p>1/ агаарын хөлөг эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах эрхгүй;</p> <p>2/ үндсэн өөрчлөлт болон үндсэн засварыг баталгаажуулах сургалтанд хамрагдаагүй;</p> <p>3/ үндсэн өөрчлөлт болон үндсэн засвартай холбоотой ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн шалгалтыг өгөөгүй.</p> <p>(ж) Энэ зүйлийн (a)–гийн дагуу эрх олгогдсон этгээд нь ИНД-66-д заасан дадлага туршлагад тавигдах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд, техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшиж байгаа эсэхээс үл хамааран олгогдсон эрхийг эдлэхгүй гэдгийг бататгах;</p>	<p>-EDTO-той холбоотой шаардлага нэмэгдсэн</p> <p>-EDTO-той холбоотой шаардлага нэмэгдсэн</p> <p>-Орчуулга, найруулга зассан</p>
---	--	--

<p>(2) хэрэв тухайн эрхэд, агаарын тээвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөрөөр EDTO нислэгийн зөвшөөрөлтэй байхыг тогтоосон нисэх онгоц багтсан бол, өмнөх 24 сарын дотор, ИНД-121.407-гийн шаардлагад тохирох давтан сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх.</p> <p>(g) Энэ зүйлийн (b), эсхүл (c)-гийн шаардлага хангаж байгаа этгээдэд энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон эрх нь, ИНД-66-гийн C Бүлгийн дагуу олгосон дүйцэх зэрэглэл, эсхүл ИНД-66-гийн D Бүлгийн дагуу олгосон <u>дүйцэх</u> MAC-ийн эрхээс хэтэрч болохгүй.</p> <p>(h) Энэ зүйлийн (e)(1)(iii) болон (f)(2)-т, хэрэв техник үйлчилгээний хөтөлбөр нь 2010 оны 11 сарын 01-нээс өмнө батлагдсан бол EDTO нислэгийн ишлэлийг ETOPS-ийн ишлэл гэж тооцно</p>	<p>(з) Энэ зүйлийн (б) болон (в)-ийн шаардлага хангасан этгээдэд, (а)-ийн дагуу олгогдсон эрх нь ИНД-66-ийн Бүлэг В-ийн дагуу олгосон зэрэглэлтэй <u>ижил хэмжээнд</u>, эсхүл ИНД-66-ийн Бүлэг Г-ийн дагуу олгосон техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээтэй ижил хэмжээнд байх бөгөөд эдгээрээс илүү эрхийг эдлэхгүй гэдгийг бататгах журамтай байна.</p>	<p>-EDTO-той холбоотой шаардлага нэмэгдсэн</p>
<p>145.61. Нислэгт тэнцэх чадварын хадгалалт</p> <p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтооно:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн ашиглаж байгаа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн гэмтэлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, шинжлэн шалгах болон дүн шинжилгээ хийх, тухайн мэдээллийг дараах этгээдэд түгээх:</p> <p>(i) холбогдох зохион бүтээх байгууллагад;</p> <p>(ii) тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн өмчлөгч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчид;</p> <p>(2) гэмтлийн зөрчлийн мэдээллийг ИНД-12-т заасны дагуу ИНЕГ-т хүргүүлэх.</p> <p>(b) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн өмчлөгч бүрд энэ зүйлийн (a)-д шаардсан журмын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж байгааг мэдээлэх журмыг тогтооно.</p>	<p>145.61. Нислэгт тэнцэх чадварын хадгалалт/Continued airworthiness</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмуудыг тогтоосон байна:</p> <p>1/ агаарын хөлөг эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт гарсан зөрчил, дутагдал, эвдрэл гэмтлийн мэдээг цуглуулах, судалгаа шинжилгээ хийх болон дараах этгээдэд мэдээллийг хүргүүлэх:</p> <p>1.1. зохион бүтээгч байгууллагад; болон</p> <p>1.2. агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг өмчлөгч, эсхүл ашиглагч агаарын тээвэрлэгч байгууллагад.</p> <p>2/ агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалтад сөргөөр нөлөөлсөн болон нөлөөлж болзошгүй аливаа эвдрэл гэмтэл, зөрчил, дутагдал, хэвийн бус ажиллагааг эрх бүхий байгууллагад ИНД-12-ын дагуу мэдээлэх;</p> <p><u>3/ агаарын хөлгийн ашиглалттай холбоотой тайлан, мэдээг ИНЕГ-т сар тутам мэдээлэх;</u></p> <p><u>4/ агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийн маягийн гэрчилгээ эзэмшигчээс НТЧ-ын холбогдолтой өгөгдөл, мэдээллийг хүлээн авах, дүгнэх, тэдгээрийн дагуу зохих өөрчлөлтийг хийж шаардлагатай хэсгүүдэд хүргүүлэх.</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p>145.63. Бүртгэл хөтлөх</p>	<p>145.63. Бүртгэл <u>тэмдэглэлд тавигдах шаардлага</u> / Requirements of records</p>	

<p>(a) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэг бүр нь ашиглалтад шилжүүлэхэд тохирч байгааг бататгахад шаардлагатай бүртгэлийг ангилах, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх журмыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(b) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1) ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд, гэрчилгээжүүлэлтийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдийн туршлага, мэргэшил, сургалт болон хүчинтэй эрхийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх;</p> <p>(2) гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж байгаа бүх агаарын хөлөг болон бүрдэл хэсэгт гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг багтаасан бүртгэл хөтлөх;</p> <p>(3) 145.55 (2)-т шаардсан багаж хэрэгсэл, төхөөрөмжийн тохируулгын болон тухайн тохируулга хийхэд ашигласан стандартын бүртгэл хөтлөх;</p> <p>(4) дараах шаардлагыг бататгах:</p> <p>(i) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын арилдаггүй байх;</p> <p>(ii) агаарын хөлгийн бүх бүртгэл нь агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч хэрэглэхэд боломжтой байх;</p> <p>(iii) энэ зүйлийн (b)-д заасан бүртгэлийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалдаг байх;</p> <p>(iv) энэ зүйлийн (b)-д шаардсан бүртгэлийг Даргын хүсэлтээр түүнд хүргүүлдэг байх.</p>	<p>(a) Өргөдөл гаргагч нь агаарын хөлгийн аливаа бүтээгдэхүүн, эсхүл бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргахад нийцсэн болохыг бататгах үүднээс техник үйлчилгээтэй холбогдсон баримт бичгийг зөв хөтлөх, бүрдүүлэх, ялгах, хадгалах, дугаарлах журамтай байна.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>1/ Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээнд заасан зөвшөөрлийн дагуу эрх олгогдсон техник үйлчилгээний ажилтан бүрийн мэргэшил, дадлага туршлага, сургалт болон эзэмшиж буй эрхийн талаар дэлгэрэнгүй бүртгэл тэмдэглэлийг хийх;</p> <p>2/ бүх агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгийн бүртгэл тэмдэглэлийг, гүйцэтгэсэн техник үйлчилгээний ажлын тодорхойлолтын хамт бүртгэл тэмдэглэлийг хийх;</p> <p>3/ ИНД-145.55-ын 2/-т заасан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид хийгдсэн тохиргоо болон тохиргоог хийхэд ашигласан стандартын талаар бүртгэл тэмдэглэл хийх;</p> <p>(в) Бүртгэл тэмдэглэлд дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ бичилт нэг бүрийг тогтмол үнэн зөв, тод гаргацтай хөтлөх;</p> <p>2/ агаарын хөлгийн талаарх бүртгэл тэмдэглэл бүрийг тухайн агаарын хөлгийн тээвэрлэгчид хүргүүлэх;</p> <p>3/ энэ зүйлийн (б)-д заасан бүртгэл, тэмдэглэлийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалах;</p> <p>4/ энэ зүйлийн (б)-д заасан бүртгэл, тэмдэглэлийг ИНЕГ-аас шаардсан тохиолдолд гаргаж өгөх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-“ИНЕГ” гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн</p>
<p>145.65. Аюулгүй байдлын удирдлага</p> <p>ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.</p>	<p>145.64. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо (энэ зүйлийг 2011 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс эхлэн мөрдөнө)/Safety management system</p> <p>(a) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч этгээд нь энэ дүрэмд нийцсэн, тогтмол дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой байна.</p> <p>1/ Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо нь дараах зүйлүүдийг агуулсан байна:</p> <p>1.1. Аюулгүй ажиллагааны бодлого;</p> <p>1.2. Аюулгүй ажиллагааг сайжруулахад чиглэсэн зорилтуудыг тогтоох, тэдгээр зорилтуудад хүрэх арга хэрэгсэлд зориулсан ажиллагаа;</p> <p>1.3. Аюулгүй ажиллагааг хангуулах, шаардлагатай түвшинд хадгалах арга хэмжээг авах ажиллагаа;</p>	<p>-D Бүлэг Шилжилтийн үеийн зохицуулалтаар орсон</p>

- 1.4. Аюулгүй ажиллагаанд оршиж буй аюулыг илрүүлэх, тэдгээрээс үүдэх эрсдэлийг үнэлэх ба удирдах ажиллагаа;
 - 1.5. Аюулыг илрүүлэх болон эрсдэлийг удирдах ажиллагааны үр дүнг бататгах аюулгүй ажиллагааны баталгаажуулах ажиллагаа;
 - 1.6. Удирдлага зохион байгуулалтыг өөрчлөх ажиллагаа;
 - 1.7. Ажилтнууд гүйцэтгэх үүрэг хариуцлагатайгаа холбогдсон сургалтанд хамрагдсан, зохих мэдлэг мэргэшил, ур чадварыг эзэмшсэн гэдгийг бататгах ажиллагаа;
 - 1.8. Осол, зөрчил, аюулыг мэдээлэх, задлан шинжлэх болон тэдгээрийг давтагдахаас урьдчилсан арга хэмжээ авах ажиллагаа;
 - 1.9. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны дагуу үүрэг хүлээсэн аливаа этгээдэд холбогдох үүрэг хариуцлагын талаар ойлголт, мэдлэг олгох ажиллагаа;
 - 1.10. Осол, зөрчил гарсан үед яаралтай арга хэмжээ авахад зориулсан онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө;
 - 1.11. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд хамаарах бүх үйл ажиллагааг багтаасан заавар;
 - 1.12. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд тодорхой үечлэлтэйгээр аудит болон хяналт, шалгалт хийх ажиллагааг;
 - 1.13. Энэ дүрэмд заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд хамаарах бусад нэмэлт шаардлагууд;
- (б) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо нь гэрчилгээ эзэмшигчийн явуулж буй үйл ажиллагаанаас хамааран үүсэж болох аюулын эрсдэл, тэдгээрийн төрөл, хэмжээ болон шинж чанар, цар хүрээнд тохирч нийцсэн байна. (в) Техник үйлчилгээний байгууллагын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо болон хэрэгжүүлэх бүтэц нь энэ дүрмийн Хавсралт 1-д заасан бүрдэл хэсгүүдийг агуулсан байна.

145.67. Техник үйлчилгээний байгууллагын Ерөнхий заавар

(а) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших [хүсэлт гаргагч нь](#) дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг [Даргад](#) ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журамд дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг

145.67. Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар / Maintenance organisation exposition

(а) [Өргөдөл гаргагч нь](#) дараах зүйлүүдийг тусгасан Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааврыг [ИНЕГ-ын](#) даргад ирүүлнэ:

- 1/ Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар болон бусад холбогдох үйл ажиллагааны зааврууд нь дараах шаардлагуудыг хангасан гэдгийг бататгасан, удирдах албан тушаалтны гарын үсэг зурсан албан ёсны мэдэгдэл, Хэрэв

зурсан мэдэгдэл:

- (i) тухайн ТҮБ-ыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
- (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг дагаж мөрдөх;

(1A) 145.65-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:

- (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
- (ii) ТҮБ-ын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;

(2) 145.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;

(3) 145.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагыг:

- (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;

- (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;

(4) 145.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(5) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хүсэлт гаргагчийн техник үйлчилгээ хийх бүх байрлал болон тухайн байрлал бүрийн байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;

6) энэ зүйлийн (a)(5)-д заасан байрлал бүрд ажиллах тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;

(7) тухайн хүсэлт гаргагчийн гүйцэтгэх ажлын цар хүрээний дэлгэрэнгүй тодорхойлолт;

(8) дараах дүрмээр шаардсан, хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй:

- (i) 145.51(b) - ажилтны ур чадварын хадгалалтын үнэлгээний

удирдах албан тушаалтан нь байгууллагын гүйцэтгэх захирал бус тохиолдолд албан ёсны мэдэгдэлд гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулж ирүүлнэ.

1.1 энэхүү дүрмийн заалт бүрийг тогтмол дагаж мөрдөж буйг бататгах арга, хэрэгслийг харуулсан ба тодорхойлсон;

1.2 зааврыг ажиллагсад байнга дагаж мөрдөж байхыг шаардсан байх; болон

2/ энэ дүрмийн 145.51-ийн (a)-ийн 1/ ба 2/-т заасан албан тушаалтнуудын нэрс болон албан тушаал;

3/ энэ зүйлийн (a)-ийн 2/-т заасан албан тушаалтны үүрэг, хариуцлага болон тухайн этгээд нь хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа холбогдсон асуудлаар байгууллагын нэрийн өмнөөс ИНЕГ-тай шууд харьцах;

4/ энэ зүйлийн (a)-ийн 2/-т заасан албан тушаалтнуудын хүлээх үүрэг хариуцлагыг байгууллагын бүтцийн зураглалаар үзүүлсэн байх;

5/ энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, өргөдөл гаргагч нь техник үйлчилгээний үйл ажиллагаа явуулах байршил бүрийн талаар тодорхойлсон байх бөгөөд тухайн байршил дахь барилга байгууламж, тоног төхөөрөмжийг нарийвчлан тусгасан байх;

6/ энэ зүйлийн (a)-ийн 5/-д заасан техник үйлчилгээний байршил тус бүрээр бүтэц зохион байгуулалтыг нарийвчлан үзүүлсэн байх;

7/ гүйцэтгэх техник үйлчилгээний ажлын багтаамжийг нарийвчлан тодорхойлсон байх;

8/ өргөдөл гаргагч нь дараах журмуудыг нарийвчлан тодорхойлсон байна:

8.1 145.51-ийн (b)-ийн 1/-д заасан, ажилтнуудын ур чадварын хадгалалтад үнэлгээ өгөх талаар;

-SMS-ийн шаардлага нэмэгдсэн

- талаар;
- (ii) 145.51(b) - ажилтны ур чадварын хадгалалтын байнгын сургалтын талаар;
- (iii) 145.52 - техник үйлчилгээний ажилтны үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтын талаар;
- (iv) 145.55(2) - багаж, эталон, техник үйлчилгээний болон тестийн төхөөрөмжийн хяналт, тохируулгын талаар;
- (v) 145.59(b)(1) - бэлдэц материал, эд анги болон иж бүрдлийн үзлэг шалгалтын талаар;
- (vi) 145.59(b)(2) - үл тохирох материал болон эд ангийн талаар;
- (vii) 145.59(b)(3) - техник үйлчилгээний үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар;
- (viii) 145.59(b)(4) - техник үйлчилгээний үйл ажиллагааны туслан гүйцэтгэх гэрээний талаар;
- (ix) 145.59(b)(5) - материал, эд анги болон иж бүрдлийг таньж тогтоох, үйлчилгээ хийх, хадгалах болон баглах талаар;
- (x) 145.59(b)(6) - агаарын хөлөг болон бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх талаар;
- (xi) 145.59(b)(7) - CAA Form One – шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ гаргах талаар;
- (xii) 145.59(b)(8) - баримт бичгийн хяналт болон түгээлтийн талаар;
- (xiii) 145.60 - ажилтанд эрх олгох талаар;
- (xiv) 145.61 - хүсэлт гаргагчийн ашиглаж байгаа агаарын хөлөг болон бүрдэл хэсгийн НТЧ-ын хадгалалтад хамаарах мэдээллийг цуглуулах болон мэдээллээр хангах талаар;
- (xv) 145.63(a) - бүртгэлийг таньж тогтоох, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах болон арчлах талаар;
- (xvi) 145.63(b) - ажилтны туршлага, ур чадвар, мэргэшил болон сургалтын бүртгэл хөтлөх талаар;

- 8.2 145.51-ийн (б)-ийн 1/-д заасан, ажилтнуудын ур чадварыг тогтмол хадгалах сургалт дадлагын талаар;
- 8.3 145.51-ийн (б)-ийн 2/-д заасан, хүний чадавхи ба хүний хүчин зүйлтэй холбогдох сургалтын талаар;
- 8.4 145.52-т заасан, техник үйлчилгээний ажилтнуудын ажлын цагийн хязгаарлалт болон хүний хүчин зүйл ба хүний чадавхийн талаар;
- 8.5 145.55-ын (а)-ийн 2/-т заасан, шалгах төхөөрөмж, техник үйлчилгээний нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмжид тохиргоо хийх болон хяналтын талаар;
- 8.6 145.59-ийн (б)-ийн 1/-д заасан, эд анги, тоног төхөөрөмж, сэлбэг материалд үзлэг хийх талаар;
- 8.7 145.59-ийн (б)-ийн 2/-т заасан, үл тохирох эд анги болон сэлбэг, материалын талаар;
- 8.8 145.59-ийн (б)-ийн 3/-т заасан, техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэх талаар;
- 8.9 145.59-ийн (б)-ийн 4/-т заасан, гэрээт техник үйлчилгээний талаар;
- 8.10 145.59-ийн (б)-ийн 5/-д заасан, эд анги, тоног төхөөрөмж болон сэлбэг материалыг боож баглах, савлах, зөөх, хадгалах, илгээх, хүлээн авах, шалгах, хаяглах талаар;
- 8.11 145.59-ийн (б)-ийн 6/-д заасан, агаарын хөлөг эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг гэрчилгээжүүлж, техник үйлчилгээнээс гаргах талаар;
- 8.12 145.59-ийн (б)-ийн 7/-д заасан, “ИНЕГ Маягт нэг-Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ” -г олгох талаар;
- 8.13 145.59-ийн (б)-ийн 8/-д заасан баримт бичгийн өөрчлөлт, шинэчлэлт болон тэдгээрийн хяналтын талаар;
- 8.14 145.60-д заасан, ажилтнуудад эрх олгох талаар;
- 8.15 145.61-д заасан, агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтад хамаарах мэдээллийг цуглуулах талаар;
- 8.16 145.63-ын (а)-д заасан, техник үйлчилгээний бүртгэл тэмдэглэлийг цуглуулах, тэдгээрийн хадгалалт, хаяглалт, индексжүүлэх талаар;
- 8.17 145.63-ын (б)-д заасан, ажилтнуудын сургалт, мэргэшил, дадлага туршлагын бүртгэл тэмдэглэлийн талаар.
- 9/ ИНД-145.53-ын (б)-ийн 3/-т заасан эд анги, тоног төхөөрөмж,

<p>(9)145.53(b)(3)-т шаардсан, эд ангийг хадгалах болон ангилан тусгаарлах байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(10) 145.53(c)-д шаардсан, тохирох орчин нөхцөлөөр хангах арга хэлбэрийн дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(11) [хүчингүй]</p> <p>(12) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам;</p> <p>(13) ИНД-147.57 болон 147.59-д шаардсантай дүйцэх журам;</p> <p>(14) зэрэглэлийн хүрээнд тухайн цар хүрээг өөрчлөх журам;</p> <p>(15) хэрэв 145.11(13)-аас (15)-д заасны дагуу, шилжүүлэх мэдэгдэл гаргах зэрэглэл авахаар зорьж байгаа бол, Ерөнхий зааварт хангамжийн шаардлагыг оруулах.</p> <p>(b) Хүсэлт гаргагч нь 145.59(b)(3)(iii)-т шаардсан журмын дагуу техник үйлчилгээ хийх тохиолдолд, техник үйлчилгээний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт тусгахгүй байж болно.</p> <p>(c) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</p>	<p>сэлбэг материалыг хадгалах, тусгаарлах болон тэдгээрийн барилга байгууламжийн талаарх дэлгэрэнгүй;</p> <p>10/ ИНД-145.53-ын (б) болон (в)-д заасан ажлын хүрээлэн буй орчныг зохих нөхцлөөр хангах арга хэрэгслийн талаарх дэлгэрэнгүй;</p> <p>11/ ИНД-145.64-д заасан, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны талаарх дэлгэрэнгүй;</p> <p>12/ ИНД-145.65-д заасан, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцооны талаарх дэлгэрэнгүй;</p> <p>13/ Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт өөрчлөлт шинэчлэлт хийх, түгээх болон хянах журам;</p> <p>14/ E1 ангилалын дагуу ИНД-141-ийн Г бүлгээр шаардсантай ижил хэмжээний сургалт явуулах журам;</p> <p>15/ Техник үйлчилгээний зөвшөөрөгдсөн ангилалын хүрээнд өөрчлөлт хийх журам.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь 145.59–ийн (б)-ийн 3.3-т заасан журмын дагуу техник үйлчилгээний үйл ажиллагааг явуулах тохиолдолд техник үйлчилгээний байршлын талаар зааварт нарийвчлан тусгахгүй байж болно.</p> <p>(в) Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааврыг ИНЕГ-ын дарга баталгаажуулсан байна.</p>	
<p>145.68. Шилжүүлэх мэдэгдэл гаргах зэрэглэл</p> <p>(a) Хэрэв хүсэлт гаргагч нь 145.11(a)(13),(14) болон (15)-д дурдсан S1, S2, эсхүл S3 зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, дараах шаардлагыг хангах үүрэгтэй:</p> <p>(1) дараах үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтны багийг томилох:</p> <p>(i) нисэхийн бүтээгдэхүүнийг хүлээн авах;</p> <p>(ii) үзлэг шалгалт болон тест хийх;</p> <p>(iii) нисэхийн бүтээгдэхүүнийг илгээх болон шилжүүлэх мэдэгдэл гаргах;</p> <p>(2) хангамжийн бүх ажиллагаанд тохирох дараах барилга байгууламжаар хангах:</p> <p>(i) хангамжийн ажиллагааг удирдан зохион байгуулах захиргааны байр;</p> <p>(ii) үзлэг шалгалт болон тест хийх байгууламж;</p> <p>(iii) хүлээн авах болон илгээх байгууламж;</p> <p>(iv) агуулахын байгууламж;</p> <p>(3) дараах мэдээллийг багтаасан, шилжүүлэх мэдэгдэл гаргах хангамжийн хяналтын журмыг тогтоох:</p>		<p>-S1, S2, S3 ангилалтай холбоотой шинэ заалт НД-19-өөс нэмэгдсэнийг оруулсан.</p> <p>-Amend.12-оор нэмэгдсэн</p>

<ul style="list-style-type: none"> (i) шилжүүлэх мэдэгдэл гаргаж байгаа хангамжийн байгууллагын нэр болон гэрчилгээний зөвшөөрлийн дугаар; (ii) гаргасан огноо; (iii) нисэхийн бүтээгдэхүүнийг тодорхойлолтоор нь, хамааралтай бол, эд анги, зураг, тодорхойлолт, серийн болон багцын дугаараар нь таньж тогтоох; (iv) хадгалах хугацаа болон нийт хугацааг багтаасан, нисэхийн бүтээгдэхүүний ашиглалттай холбоотой хязгаарлалт болон тохирол; (v) агуулагдсан тоо хэмжээ; (vi) үйлдвэрлэлийн явцад хийсэн модификацийн дэлгэрэнгүй мэдээлэл; <p>(4) бүртгэл хөтлөх дараах журмыг тогтоох:</p> <ul style="list-style-type: none"> (i) үнэн зөв гаргацтай бөгөөд байнгын арилдаггүй байдалтай байх; (ii) тухайн мэдээллийг оруулснаас хойш 7 жил хадгалдаг байх. 		
<p>С Бүлэг-Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>БҮЛЭГ В. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГУУД/OPERATING REQUIREMENTS</p>	
<p>145.101. <u>Байнгын</u> хэрэгжилт ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:</p> <ul style="list-style-type: none"> (1) Ерөнхий зааварт заасан ажлын байрлал тус бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгална; (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журмыг дагаж мөрдөнө; (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгана; (4) В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангана; (5) ашиглалтад шилжүүлсэн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь тэдгээрийн нислэгт тэнцэх нөхцөлд байгааг тодорхойлно. 	<p>145.101. Хэрэгжилтийг <u>тогтмолжуулах/Continued compliance</u></p> <p>(a) Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> 1/ Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт тусгасан ажлын байр бүрт уг зааврын хүчин төгөлдөр нэгээс доошгүй хувийг байлгах; 2/ Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт заасан бүх журмуудыг тогтмол мөрдөж ажиллах; 3/ ажил үүргээ гүйцэтгэхэд өөрт хамааралтай зааварт тусгагдсан заалт бүрийг ажилтан бүр биелүүлэх; 4/ энэ дүрмийн Б.Бүлэгт заасан шаардлагуудыг биелүүлэх ба зохих стандартуудыг тогтмол дагаж мөрдөх; 5/ техник үйлчилгээнээс гарч буй агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг бүрийг нислэгт тэнцэх чадвартайг тодорхойлох. 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>145.103. Эрх эзэмшигчийн эрх, хязгаарлалт</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын дагуу дараах эрх эзэмшсэн байхаас бусад тохиолдолд аливаа этгээд нь дараах гэрчилгээжүүлэлтийг хийхгүй байх үүрэгтэй:</p>	<p>145.103. Гэрчилгээ эзэмшигчийн эрх ба хязгаарлалт / Privileges and limitations of authorisation holders</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигчээс зохих эрх олгогдоогүй этгээдийг дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p>	

<p>(1) хэрэв тухайн техник үйлчилгээг энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаар хийлгэхийг шаардсан бол, техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэх; эсхүл</p> <p>(2) агаарын хөлөг болон бүрдэл хэсэгт хийсэн том хэмжээний модификаци болон том хэмжээний засвар нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлэх; эсхүл</p> <p>(3) S1, S2, эсхүл S3 зэрэглэлийн хүрээнд шилжүүлэх мэдэгдэл гаргах.</p> <p>(b) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх эрх олгогдсон этгээд нь дараах эрхтэй:</p> <p>(1) тухайн эрхэд заасан агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх, эсхүл хяналт тавих;</p> <p>(2) тухайн эрхэд заасан агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийсний дараа ашиглалтад шилжүүлэх.</p> <p>(c) Энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэх эрх олгогдсон этгээд нь ИНД-43-ын С Бүлгийн дагуу тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэх үүрэгтэй.</p>	<p>1/ хэрэв тухайн техник үйлчилгээ нь энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаар хийгдсэн байхыг шаардсан нөхцөлд агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргахыг;</p> <p>2/ агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт хийгдсэн үндсэн засвар болон үндсэн өөрчлөлтийг зөвшөөрөгдсөн техникийн өгөгдлийн дагуу шалгаж баталгаажуулахыг.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигчээс дараах эрх олгогдсон этгээд агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргана:</p> <p>1/ Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт техник үйлчилгээний ажлыг хянах буюу гүйцэтгэх;</p> <p>2/ Техник үйлчилгээг гүйцэтгэсний дараа агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах.</p> <p>(в) Энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас эрх олгогдсон этгээд нь агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт техник үйлчилгээг гүйцэтгэсний дараа ИНД-43-ын В Бүлгийн дагуу техник үйлчилгээнээс гаргана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-Amend.1-ээр өөрчлөгдсөн</p>
<p>145.105. Гэрчилгээ эзэмшигчийн <u>байгууллагын өөрчлөлт</u></p> <p>(a) Энэ зүйлийн (d) болон (f)-ийг харгалзан, ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 145.67-д шаардсан эзэмшигчийн Ерөнхий зааврын дэлгэрэнгүй мэдээллийн нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллагын хүчинтэй тодорхойлолт хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах үүрэгтэй.</p> <p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) Ерөнхий зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн болон бусад дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгааг бататгах;</p> <p>(2) Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх.</p> <p>(c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд дараа нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээс өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:</p>	<p>145.105. Гэрчилгээ эзэмшигч <u>байгууллагад орох өөрчлөлт/Changes to certificate holder's organization</u></p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (г) болон (e)-д заасан шаардлагыг хангаж, Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт орох өөрчлөлтийг ИНД-145.67-д заасны дагуу хийх бөгөөд байгууллагын үндсэн чиг үүрэг, тодорхойлолт хэвээр үлдэнэ гэдгийг бататгана.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг бататгасан байна:</p> <p>1/ Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт орсон засвар, өөрчлөлт бүр нь энэ дүрэм болон бусад холбогдох дүрмийн шаардлагыг хангасан болохыг;</p> <p>2/ засвар, өөрчлөлт нь Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан журмын дагуу хийгдсэн болохыг.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт оруулах засвар, нэмэлт, өөрчлөлтийн хувь бүрийг ИНЕГ-ын даргаар баталгаажуулна.</p> <p>(г) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд ИНЕГ-ын даргаас урьдчилан зөвшөөрөл авч, Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт зохих өөрчлөлтийг хийнэ:</p>	<p>-Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт “оруулсны дараа” Даргад мэдэгддэг байхаар шаардсаныг “оруулах” гэж ирээдүй цагаар орчуулснаар “бүх өөрчлөлт”-ийг Даргад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсны дараа хийх болгож өөрчилсөн байна. <i>Senior person</i> - албан тушаалтан – удирдах ажилтан</p>

<p>(1) Гүйцэтгэх захирал; (2) нэр заагдсан удирдах ажилтнууд; (3) техник үйлчилгээний зэрэглэл; (4) зэрэглэлийн доторх цар хүрээг өөрчлөх журам; (5) техник үйлчилгээ хийгдэж байгаа байрлал; (6) техник үйлчилгээг гэрчилгээжүүлэх ажилтанд эрх олгох журам; (7) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол.</p> <p>(е) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.</p> <p>(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (е)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.</p>	<p>1/ <u>удирдах албан тушаалтан</u> өөрчлөгдөх; 2/ зааварт тусгагдсан албан тушаалтнууд өөрчлөгдөх; 3/ техник үйлчилгээний ангилалыг өөрчлөх; 4/ ангилалын хүрээнд өөрчлөлт хийх журмыг өөрчлөх; 5/ техник үйлчилгээг гүйцэтгэх <u>байршил</u> өөрчлөгдөх; 6/ техник үйлчилгээг <u>баталгаажуулах</u> ажилтнуудад эрх олгох журамд өөрчлөлт оруулах.</p> <p>(д) Энэ зүйлийн (г)-д заасан аль нэг өөрчлөлтийг хийж байх хугацаанд эсхүл хийгдсэний дараа гэрчилгээ эзэмшигчийн явуулах үйл ажиллагааны нөхцлийг ИНЕГ-ын дарга тодорхойлж өгч болно.</p> <p>(е) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (д)-д заасан ИНЕГ-ын даргын тодорхойлсон аливаа нөхцлийг дагаж мөрдөнө.</p> <p>(ж) Хэрэв энэ дүрмийн шаардлагын дагуу оруулсан аливаа өөрчлөлтийн улмаас Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээнд өөрчлөлт орох бол эзэмшигч нь гэрчилгээг ИНЕГ-ын даргад нэн даруй ирүүлнэ.</p> <p>(з) ИНЕГ-ын даргаас нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч нь Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий зааварт оруулна.</p>	<p>Location –байршил – байрлал</p> <p>Certification баталгаажуулах гэрчилгээжүүлэх</p> <p>(7) заалт нэмэгдсэн</p>
<p>D Бүлэг - Шилжилтийн зохицуулалт</p>		<p>-Шинэ Бүлэг нэмэгдсэн</p>
<p>145.151. ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаанд оролцдог агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийдэг ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт</p> <p>(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна: (1) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч: (i) ИНД-121.1, эсхүл 125.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт техник үйлчилгээ хийдэг; (ii) энэ зүйлийн (a)(1)(i)-д дурдсан агаарын хөлгийн бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийдэг; (2) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч: (i) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх; (ii) энэ зүйлийн (a)(2)(i)-д дурдсан агаарын хөлгийн бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх;</p>	<p>ХАВСРАЛТ А. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРДЭЛ ХЭСГҮҮД/ COMPONENTS OF SAFETY MANAGEMENT SYSTEM</p>	<p>-2010 онд SMS-ийн зохицуулалтыг энэ хэлбэрээр оруулсан байсныг Шинэ Бүлгээр зохицуулсан</p>

(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:

(1) 145.51(a)(2)(iii)-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;

(2) 145.65-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 145.155-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;

(3) 145.67(a)(1A)(i)-ийг;

(4) 145.67(a)(3)(ii)-ыг;

(5) 145.67(a)(6A)-г.

(c) Гүйцэд бөглөсөн ИНЕГ маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-нээс хойш;

(2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-нээс өмнө.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

(1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;

(2) тухайн байгууллага 145.65-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга:

(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;

(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн огноог тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

(1) тухайн байгууллагын хүчин чадал;

(2) тухайн байгууллагын төвөгшил;

(3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;

(4) аливаа гэрчилгээг сунгах хугацаа;

(5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;

(6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2020 оны 2 сарын 1-нээс хойш

-Amend.14-өөр
нэмэгдсэн

<p>байж болохгүй.</p> <p>(г) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.</p> <p>(h) Энэ зүйл нь 2020 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.</p>		
<p>145.153. ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаанд оролцдоггүй агаарын хөлөг эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийдэг ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт</p> <p>(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:</p> <p>(1) ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч:</p> <p>(i) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт техник үйлчилгээ хийдэггүй;</p> <p>(ii) энэ хэсгийн (1)(i)-д дурдсан агаарын хөлгийн бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийдэггүй;</p> <p>(2) ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч:</p> <p>(i) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт техник үйлчилгээ хийхгүй;</p> <p>(ii) энэ зүйлийн (а)(2)(i)-д заасан агаарын хөлгийн бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийхгүй;</p> <p>(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:</p> <p>(1) 145.51(а)(2)(iii)-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;</p> <p>(2) 145.65-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 145.155-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;</p> <p>(3) 145.67(а)(1А)(i)-ийг;</p> <p>(4) 145.67(а)(3)(ii)-ыг;</p> <p>(5) 145.67(а)(6А)-г;</p> <p>(c) Гүйцэд бөглөсөн ИНЕГ маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (а)(2)-ын дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас хойш;</p> <p>(2) энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2020 оны 7 сарын 30-наас өмнө.</p> <p>(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:</p>		<p>-Amend.14-өөр НЭМЭГДСЭН</p>

<p>(1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;</p> <p>(2) тухайн байгууллага 145.65-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.</p> <p>(e) Дарга, хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол:</p> <p>(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;</p> <p>(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн огноог тогтооно.</p> <p>(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:</p> <p>(1) тухайн байгууллагын хүчин чадал;</p> <p>(2) тухайн байгууллагын төвөгшил;</p> <p>(3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;</p> <p>(4) гэрчилгээг сунгах хугацаа;</p> <p>(5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;</p> <p>(6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.</p> <p>(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.</p> <p>(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.</p>		
<p>145.155. ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт</p> <p>(a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 145.151(b)(1)(ii) болон 145.153(b)(1)(ii)-г шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.</p> <p>(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилт болон үйлчлүүлэгчийн хүсэл хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;</p> <p>(2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг байхыг бататгах журам;</p>		

- (3) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг залруулсан болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;
- (4) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
- (5) хүсэлт гаргагчийн байгууллагын аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх зорилгоор аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
- (6) энэ Дүрмийн шаардлагыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохиромжтой болон үр дүнтэй байдлыг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам.
- (с) Аюулгүй байдлын бодлогын журам нь тухайн аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгож хэрэгжүүлж, мөрдөж байгааг бататгах ёстой.
- (d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах залруулах арга хэмжээг эргэн хянах;
 - (3) залруулах арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (4) залруулах арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн хянах;
 - (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (4) авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь:
- (1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцож аудит хийх байрлал болон давтамжийг тодорхойлох;
 - (2) аудитыг тухайн үйл ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэггүй сургалтад хамрагдсан аудитын ажилтан гүйцэтгэдэг болохыг бататгах;
 - (3) аудитын үр дүнг аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудит хариуцсан менежер мэдээлдэг болохыг бататгах;
 - (4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит

<p>хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;</p> <p>(5)авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн хянах аудит хийдэг болохыг бататгах ёстой.</p> <p>(g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь:</p> <p>(1)тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг үндэслэн чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлох;</p> <p>(2)чанар баталгаажуулалтын тогтолцооны дүгнэлт хийх хариуцлага хүлээсэн менежерийг тодорхойлох;</p> <p>(3)тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж бүртгэл хөтөлдөг болохыг бататгах ёстой.</p> <p>(h)Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй байна.</p> <p>(i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.</p>		
---	--	--

Дүрмийн боловсруулалтын хэлтэс